



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 41/179

Номгон

“ Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн  
комиссыг шинэчлэн байгуулах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/400 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга- Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга- Эрүүл мэндийн газрын Магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Ажлын албаны дарга бөгөөд - Эрүүл мэндийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын Эмийн бодлогын мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн захирал

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг баримтлан, үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлага, өрсөлдөөнд нөлөөлөх байдлыг үнэлж, тодорхойлон тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлага, мэргэжлийн арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллан тайланг жил бүр Засаг даргад танилцуулахыг Комиссын даргад үүрэг болгосугай.


3. Комиссын эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааны өдөр тутмын үйл ажиллагааг

601220445

гүйцэтгэх ажлын албыг байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т хариуцуулсугай.

4.Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс байгуулах тухай” А/580 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Мөнхсоёл)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН